



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 1162

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлж, малчин өрхийг мэдээллээр хангах анхан шатны хоршоог байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: (Засаг даргын орлогч)
- Гишүүд: (Засаг даргын Тамгын газрын дарга)
- (Бэхт багийн Засаг дарга)
- (Улсын бүртгэгч)
- (Газрын даамал)
- (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

(Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

(Эрүүл мэндийн төвийн Бэхт багийн эмч)

Нарийн бичгийн дарга:

(Нэрт багийн Засаг дарга)

2.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээ, иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг хийх орчин нөхцлийг хангахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С. СУГАРМАА